



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ТАМГЫН ГАЗАР

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН САНАЛ, ТӨСӨЛ

Сэдэв: Парламентын ардчиллыг төлөвшүүлж,  
ард түмний засаглах эрхийг хангах

ТӨРИЙН ОРДОН  
2019 он



## 1.УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН ТООГ 108 БОЛГОЖ, СОНГУУЛИЙГ ХОЛИМОГ ТОГТОЛЦООГООР ЯВУУЛНА

### Үндсэн хуулийн заалт:

21.1.Улсын Их Хурал нэг танхимтай,  
далан зургаан гишүүнтэй байна.

### Төслийн заалт:

21.1.Улсын Их Хурал нэг танхимтай,  
нэг зуун найман гишүүнээс бүрдэх  
бөгөөд тавин дөрвөн гишүүнийг нэг  
мандат бүхий сонгуулийн тойргоос  
мажоритар тогтолцоогоор, тавин  
дөрвөн гишүүнийг сонгуулийн нэгдсэн  
нэг тойргоос пропорционал  
тогтолцоогоор тус тус сонгоно.



## 2.УЛСЫН ИХ ХУРЛЫН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААГ 5 ЖИЛ БОЛГОНО

### Үндсэн хуулийн заалт:

21.2.Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, **дөрвөн** жилийн хугацаагаар сонгоно.

24.2.Улсын Их Хурлын дарга, дэд даргын бүрэн эрхийн хугацаа **дөрвөн** жил байх бөгөөд хуульд заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө чөлөөлж, огцруулж болно.

### Төслийн заалт:

21.2.Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, **таван** жилийн хугацаагаар сонгоно.

24.2.Улсын Их Хурлын дарга, дэд даргын бүрэн эрхийн хугацаа **таван** жил байх бөгөөд хуульд заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө чөлөөлж, огцруулж болно.



## 3. ИРГЭНИЙ СОНГОХ ЭРХЭД ХУУЛЬ БУСААР НӨЛӨӨЛӨХ, СААД УЧРУУЛАХ ОРОЛДЛОГО, ХУЙВАЛДААНЫГ ТӨРИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТ ГЭЖ ҮЗНЭ

### Үндсэн хуулийн заалт:

21.4. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.

### Төслийн заалт:

21.4. Улсын Их Хурлын сонгуулийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу мажоритар болон пропорционал тогтолцоогоор явуулна. Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэний сонгох эрхэд хууль бус аргаар нөлөөлөх буюу саад учруулах оролдлого, хуйвалдааныг Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт халдсан гэмт хэрэг гэж үзнэ. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.



## 4.УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙГ ЕРӨНХИЙ САЙДААС БУСАД ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮНЭЭР АЖИЛЛАХЫГ БҮРЭН ХОРИГЛОНО

### Үндсэн хуулийн заалт:

29.1.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь **Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад**, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.

### Төслийн заалт:

29.1.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь **Ерөнхий сайдаас бусад**, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.



## 5.ХУУЛЬ САНААЧЛАХ ЭРХИЙН ХҮРЭЭ, ХЯЗГААРЫГ ХУУЛЬЧЛАН ТОГТООНО

### Үндсэн хуулийн заалт:

26.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ.

### Төслийн заалт:

26.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно.



## 6.УЛС ТӨРИЙН НАМ ҮНДСЭН ХУУЛИАР ТОДОРХОЙЛСОН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛНА



### Төслийн заалт:

19<sup>11</sup>.Нам нь нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодлын үүднээс сайн дураар эвлэлдсэн, нэгдмэл, тодорхой үзэл санааны хүрээнд улс төрийн үйл ажиллагаа явуулж, **төрийн бодлогыг тодорхойлох** зорилготой Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн.



## 7.УЛС ТӨРИЙН НАМ БАЙГУУЛАХ БОЛЗЛЫГ ШИНЭЧИЛЖ, ГИШҮҮНИЙ БҮРТГЭЛИЙН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО



### Төслийн заалт:

19<sup>1</sup>2.Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий **тавин мянга нэгээс** доошгүй тооны иргэн нэгдэж байгуулах бөгөөд гишүүний бүртгэл, **өөрчлөлтийг сонгуулийн төв байгууллага** хөтөлнө.





## 8.НАМЫН ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БОЛОН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО



### Төслийн заалт:

19<sup>13</sup>.Намын дотоод зохион байгуулалт нь ардчилсан зарчимд нийцсэн байна. Намын удирдлага болон удирдах дээд байгууллагын сонгуулийг сонгуулийн төв байгууллага, дотоод бусад сонгуулийг холбогдох сонгуулийн байгууллага хариуцна.



## 9.НАМЫН ӨМЧИЙН ЭРХИЙГ ХЯЗГААРЛАЖ, САНХҮҮЖИЛТИЙГ ИЛ ТОД БОЛГОНО



### Төслийн заалт:

19<sup>14</sup>.Нам үл хөдлөх болон ахуйн хэрэгцээнийхээс бусад үнэ бүхий хөдлөх **хөрөнгө өмчлөхгүй**. Намын орлогын эх сурвалж, зарцуулалт **НИЙТЭД ил тод байна**. Намын зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүүжилт, ил тод байдал болон төрөөс дэмжлэг үзүүлэх болзол, **журмыг хуулиар ТОГТООНО**.



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ТАМГЫН ГАЗАР

АНХААРАЛ ТАВЬСАНД  
БАЯРЛАЛАА